



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2019.06.21 № 1-1/2991
танаи 2019.06.14-ны № 01/3200-т

Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалыг Захиргааны өрөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ~~44/14~~ дугаарт бүртгэснийг мэдэгдье.



1516022243
Дод. уат 25.06.2019



Захиргааны жэм хөмжүүсний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 06 сарын 21.-ны
одорийн үүрүү дугаар бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУИНАЛ

2019 оны 06 сарын 12-ны 187


улаанбаатар.mn

Багц дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн багц дүрэм болох "Монгол Улсад агаарын хөлгийг бүртгэх дүрэм"-ийг нэгдүгээр, "Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох дүрэм"-ийг хоёрдугаар, "Агаарын хөлөг, түүний эд ангиудын үйлчилгээ засварын газар, нисэхийн үйлчилгээний байгууллагад үзлэг, шалгалт хийх, тэдгээрт нэвтрэх дүрэм"-ийг гуравдугаар, "Нисэхийн салбарт гэрээгээр ажил гүйцэтгүүлэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллах, агаарын хөлгийн үзлэг, шалгалт хийх эрх олгох дүрэм"-ийг дөрөвдүгээр, "Монгол Улсын хилээр агаарын хөлөг нэвтрэх, аэродромд буух, хөөрөх, түүнчлэн Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх, нислэгийн хөдөлгөөн удирдах дүрэм"-ийг тавдугаар, "Агаарын хөлгийг зорчигч, тээш, ачаа тээвэрлэх болон бусад зориулалтаар ашиглах дүрэм"-ийг зургадугаар, "Иргэний нисэхэд навигацийн хэрэгслийг ашиглах явцад гарч болох сөрөг нөлөөг багасгах, тийм нөлөөллөөс болон агаарын хөлөгт аюул учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тоног төхөөрөмж, гэрэл, дохиог суурилуулах, ашиглах дүрэм"-ийг долдугаар, "Агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, үр өгөөж, зохицуулалтыг хангах, агаарын хөлөг болон зорчигч, эд зүйлсийн аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм"-ийг наймдугаар, "Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах байгууллагыг гэрчилгээжүүлэх дүрэм"-ийг есдүгээр, "Агаарын хөлөгтэй харилцах холбоо, дохиог ашиглах дүрэм"-ийг аравдугаар, "Монгол Улсын агаарын зайн хориотой бүсэд нислэг үйлдэх дүрэм"-ийг арваннэгдүгээр, "Иргэний нисэхийн холбогдолтой бүх төрлийн гэрчилгээ, үнэмлэх болон бусад баримт бичгийн загварыг тодорхойлох, тэдгээрийг олгох, үйлчлэлийг нь түр зогсоох, хураах, хадгалах дүрэм"-ийг арванхөөрдугаар, "Нислэг, түүний үйл ажиллагаанд оролцогч ажилтнуудын ажлын цагийг хуваарилах дүрэм"-ийг арвангуравдугаар, "Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам"-ыг арвандөрөвүгээр, "Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөгт дуу чимээний хязгаарлалт тогтоох дүрэм"-ийг арвантавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Иргэний нисэхийн багц дүрмийг мөрдөж хэрэгжүүлэн, дүрмийн хэрэгжилтэд үнэлгээ, шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-т тус тус даалгасугай.




3. Иргэний нисэхийн багц дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан дараах тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

- Дэд бүтцийн сайдын 2002 оны "Дүрэм батлах тухай" 261 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-108 "Агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр". Дэд бүтцийн сайдын 2002 оны "Дүрэм батлах тухай" 353 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-109 "Ачаа тээвэр зуучлагчийн аюулгүй байдлын хөтөлбөр", Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны "Дүрэм батлах тухай" 77 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ИНД-12 "Осол, зэрчлийн талаар мэдээлэх", Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны "Дүрэм батлах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 78 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-139 "Аэродромын гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагаа", Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны "Дүрэм батлах тухай" 111 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-21 "Бүтээгдэхүүн" болон эд ангийн гэрчилгээжүүлэлт", 3 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-43 "Техник үйлчилгээний ерөнхий дүрэм", 4 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-61 "Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл", 5 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-63 "Нисгэгчээс бусад нисгэх багийн гишүүдийн үнэмлэх, зэрэглэл", 7 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-66 "Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл", 8 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-71 "Агаарын зайл тоогох", 12 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-141 "Иргэний нисэхийн сургалтын байгууллага, гэрчилгээжүүлэлт", 13 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-145 "Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт".

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны "Дүрэм батлах тухай" 160 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-39 "Нислэгт тэнцэх чадварын удирдамж", 3 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-47 "Агаарын хөлгийн бүртгэл, таних тэмдэг", 4 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-67 "Иргэний нисэхийн эрүүл мэндийн стандарт, гэрчилгээ", 5 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-73 "Тусгай зориулалтаар ашиглах агаарын зайл", 6 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-77 "Нам өндрийн нислэгт саад учруулах барилга, байгууламж болон үйл ажиллагаа", 7 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-92 "Аюултай ачаа тээвэрлэх", 8 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-95 "Хэрэглэлийн нислэгийн журмаар буултын ойртолт үйлдэх ба сансрын навигаци ашиглах", 9 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-101 "Хүнгүй нисдэг төхөөрөмж болон автожир", 10 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-103 "Хэт хөнгөн агаарын хөлөг-үйл ажиллагаа", 11 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-104 "Планер-үйл ажиллагаа", 12 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-105 "Шүхрийн үйл ажиллагаа", 13 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-106 "Дельтапланы үйл ажиллагаа", 15 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-129 "Гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх", 20 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-149 "Нисэх клуб, гэрчилгээжүүлэлт", 21 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-157 "Аэродром байгуулах, өөрчлөх, ашиглалтаас хасах", 25 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-337 "Ачаа тээвэр зуучлалын байгууллага, гэрчилгээжүүлэлт";

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 211 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ИНД-26 "Нислэгт тэнцэх чадварын нэмэлт, шаардлагууд", 2 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-140 "Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт", 3 дугаар хавсралтаар батлагдсан ИНД-148 "Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэгч байгууллага, гэрчилгээжүүлэлт";



- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны "Дүрэм батлах тухай" 348 дугаар тушаалаар батлагдсан ИНД-65 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл";

- Зам, тээврийн сайдын 2015 оны 320 дугаар тушаалаар батлагдсан ИНД-341 "Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, хураамжийн хэмжээг тогтоох" тухай тушаал.

